

**ЗӨВШӨӨРӨВ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ОРЛОГЧ С.ОРГОДОЛ**



**ДУУДЛАГА ХУДАЛДАА ЯВУУЛАХ УДИРДАМЖ**

**Нэг. Ерөнхий зүйл**

Neige & Bechtel Bank LLC

- 1.1 Энэхүү удирдамж нь “Худалдаа, хөгжлийн банк” ны (цаашид “банк” гэх) өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулах үйл ажиллагааг олон нийтэд танхимын дуудлага худалдаа хэлбэрээр (цаашид “дуудлага худалдаа” гэх) зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Банк нь Хавсралт 1-д заасан өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгүүдийг дуудлага худалдаанд оруулна.

**Хоёр. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх**

- 2.1 Дуудлага худалдаанд оролцох оролцогчдын нэрсийг урьдчилан цахим шуудангаар болон бичгээр авна.
- 2.2 Дэнчингийн мөнгийг тогтоосон хугацаанд шилжүүлээгүй тохиолдолд бүртгэлээс хасах.
- 2.3 Дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсэг нь дуудлага худалдаанд оролцох оролцогчдын бүртгэлийн хүснэгт (Хавсралт 2)-ийг урьдчилан бэлдсэн байна.
- 2.4 Дуудлага худалдаанд оролцохыг хүснэгч нь дуудлага худалдааны удирдамжийг зөвшөөрсөн тохиолдолд Бүртгэлийн хүснэгтэд гарын үсэг зурж баталгаажуулна.

**Гурав. Дуудлага худалдаанд оролцогч**

- 3.1 Дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ илэрхийлж, дэнчингээ зохих журмын дагуу тавьсан Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хувь хүн бүгд эрх тэгш дуудлага худалдаанд оролцох эрхтэй. Дуудлага худалдаагаар худалдаа зүйл нь газар өмчлөх эрх бол зөвхөн Монгол улсын иргэн, эзэмших, ашиглах эрх бол зөвхөн Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцох эрхтэй.
- 3.2 Дуудлага худалдаанд оролцогч иргэн 50,000.00 төгрөг, аж ахуйн нэгж, байгууллага 100,000.00 төгрөгийн хураамж төлөх ба энэхүү хураамжийг буцаан олгохгүй.
- 3.3 Дуудлага худалдаанд оролцогч үнэ өсгөх доод хэмжээ нь 500,000.00 төгрөг байна.

**Дөрөв. Дуудлага худалдаанд оролцогчийн эрх, үүрэг**

- 4.1 Дуудлага худалдаанд оролцогч дараах эрх эдэлнэ:
  - 4.1.1 Дуудлага худалдаанд оруулах хөрөнгетэй холбоотой бүхий л мэдээлэлтэй үнэ төлбөргүй танилцах;
  - 4.1.2 Дуудлага худалдаанд ялаагүй бол дэнчингээ буцаан авах.
- 4.2 Дуудлага худалдаанд оролцогчид дараах үүрэг хүлээнэ:
  - 4.2.1. Дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ хугацаанд нь ирүүлэн, дэнчингээ төлсөн баримтаяа хавсаргасан байх;
  - 4.2.2. Дуудлага худалдааны дэг журмыг сахих;
  - 4.2.3. Дуудлага худалдаанд ялсан тохиолдолд худалдан авсан хөрөнгийн үнийг энэ журмын 7.2-д заасан хугацаанд төлөх.

**Тав. Дуудлага худалдааны дэнчин**

- 5.1 Дуудлага худалдаагаар худалдаа хөрөнгийн дэнчингийн хэмжээ нь дуудлага худалдааны анхны үнийн дүнгийн 10%-тай тэнцүү байна.
- 5.2 Ялагчаас бусад оролцогчдын дэнчинг дуудлага худалдаа болсон өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор буцааж олгоно.
- 5.3 Дуудлага худалдаанд ялаагүй тохиолдолд оролцогч нь дэнчингээ ямар нэг шимтгэлгүйгээр буцаан авна.

- 5.4 Дуудлага худалдаанд ялсан оролцогчийн худалдан авах хөрөнгийн үнийн төлбөрт дэнчинг оролцуулж тооцно.
- 5.5 Дуудлага худалдааны ялагч нь худалдан авсан хөрөнгийн үнийг энэ удирдамжийн 7.2-д заасан хугацаанд төлөөгүй бол тухайн хөрөнгийг худалдаж авах эрхээ алдах бөгөөд энэ тохиолдолд дэнчинг буцаан олгохгүй.

#### **Зургаа. Дуудлага худалдаа явагдах аргачлал, дараалал**

- 6.1 Дуудлага худалдаанд оролцохыг хүссэн этгээд энэ тухай хүсэлтээ үнэн зөв гаргаж, түүнд дэнчин тавьсан баримтаяа хавсаргаж дуудлага худалдааны комисст хүлээлгэн өгнө.
- 6.2 Дуудлага худалдаанд оролцох нэгээс илүү хүсэлт ирээгүй тохиолдолд дуудлага худалдааны комисс дуудлага худалдаа явуулахгүй болсон тухайгаа оролцогчид мэдэгдэх бөгөөд дахин дуудлага худалдаа явагдах талаар мэдээлнэ.
- 6.3 Дуудлага худалдаанд оролцох хүсэлт гаргагчдын материалын бүрдлийг шалган авч оролцогчдын жагсаалтыг гарган, дуудлага худалдаанд оролцогчид хувийн дугаар олгоно.
- 6.4 Дуудлага худалдаанд оролцогчид үнийн саналаа ээлж дараалан ёсгөж хэлнэ. Дуудлага худалдааны ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд байна.
- 6.5 Дуудлага худалдаа дараах дарааллаар явуулна:
  - 6.5.1 Дуудлага худалдаанд оролцогчдыг байраа эзлэхийг гурав дахь удаагаа урихад оролцохоор бүртгүүлэгч хүрэлцэн ирээгүй бол түүнийг дуудлага худалдаанд оролцохоос татгалzsанд тооцож, энэ тухай дуудлага худалдааны тэмдэглэлд бичүүлнэ;
  - 6.5.2 Бүртгэлийн ажиллагаа дууссаны дараа комиссын дарга дуудлага худалдаа албан ёсоор эхэлснийг зарлана;
  - 6.5.3 Хөтлөгч дуудлага худалдааны удирдамжтай танилцсан байх ёстойг оролцогчдод анхааруулна.
  - 6.5.4 Хөтлөгч худалдагдаа хөрөнгийн тухай товч танилцуулж, дуудлага худалдааны үнийг ёсгөн хэлэх доод хэмжээг зарласнаар дуудлага худалдаа эхэлнэ;
  - 6.5.5 Оролцогч үнийн санал хэлэхэд хөтлөгч тэр үнийн саналыг гурван удаа давтаж хэлэх ба энэ хугацаанд бусад оролцогчид түүнээс дээш үнийн санал хэлээгүй тохиолдолд хөтлөгч “буулаа” гэж хэлээд “нэг”, “хоёр”, “гурав” гэж тоолсны дараа тухайн хөрөнгө худалдагдсаныг зарлаж дуудлага худалдаа хаасныг мэдэгдэнэ.

#### **Долоо. Дуудлага худалдааны ялагчид худалдан авсан хөрөнгийг шилжүүлэх**

- 7.1 Ялагч нь дуудлага худалдаа явагдсан өдрөөс хойш ажлын 3-н өдрийн дотор Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулна. Гэрээнд дор дурдсан зүйлсийг заавал тусгана:
  - 7.1.1. Худалдан авсан үл хөдлөх хөрөнгийн нэр, тодорхойлолт, байршил;
  - 7.1.2. Хөрөнгийн гэрчилгээний дугаар, түүнд заагдсан бусад мэдээлэл;
  - 7.1.3. Дуудлага худалдаанд оролцохдоо тавьсан дэнчингийн хэмжээ;
  - 7.1.4. Худалдан авсан үнэ;
  - 7.1.5. Үнэ төлөх хэлбэр.
- 7.2 Дуудлага худалдааны ялагч хуанлийн 7 хоногийн дотор төлбөрийг бүрэн хийнэ. Гэрээнд заасан үнийг бүрэн төлсний дараа хөрөнгийн өмчлөх болон эзэмших, ашиглах эрхийг шилжүүлнэ.
- 7.3 Ялагч 6.2-д заасан хугацаанд төлбөрийг шилжүүлээгүй тохиолдолд дуудлага худалдааны доод үнийн шаардлага хангасан тохиолдолд дараагийн оролцогчид шилжүүлнэ.

**Ажлын хэсэг  
2018 он**